

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
<b>Үүрэг, даалгавар-НЭГ:</b> Нийслэлийн 2023 оны төсвийн төсөл, Өмч хувьчлалын жагсаалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл зэрэг асуудлуудыг боловсруулж бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Газар зохион байгуулалтын алба, бусад байгууллагууд/				
1.	Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албанд эзэмшиж буй газраа өмчлөх хүсэлт 326, <a href="http://www.egazar.gov.mn">www.egazar.gov.mn</a> , e-mongolia “аппликейшинаар 89, нийт 415 иргэн материал ирүүлснийг 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 18/899 тоот албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар өмчлөлийн хэлтэст хүргүүлсэн.	=	2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 415 нэгж талбарыг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны “Газар өмчлөлийн шийдвэрийн төслийг бэлтгэх” ажлын хэсгийн хурлаар оруулахаар бэлтгэл ажлыг хангасан.	70
<b>Үүрэг, даалгавар ХОЁР:</b> Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тогтмол өгч, айл өрх бүрийн зуух яндангийн битүүмжлэл, аюулгүй байдлыг хангуулж, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах. /Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, бусад байгууллагууд/				

2.	<p>Дүүргийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын эрчимжүүлэх тухай” А/341 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Онцгой байдлын хэлтсээс Засаг даргын Тамгын газар, “Таван толгой түлш” ХХК-тай хамтран 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Зунжин” худалдааны төвд “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” өдөрлөг арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>“Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” өдөрлөгийн арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч Д.Отгонбаатар, Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч Х.Алтаншагай, Нийслэлийн Онцгой байдлын газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, хурандаа Г.Нэргүй, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Батбилэг, тус дүүрэгтэй хамтран ажиллагч нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллагын төлөөлөл болон “Таван толгой түлш” ХХК-ийн ажилтнууд, 7-21, 24 дүгээр хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагч, нийтийн эргүүл, иргэд идэвхтэй оролцлоо.</p> <p>“Таван толгой түлш” ХХК-ийн ажилчид сайжруулсан шахмал түлшний “Сайн карт”-ыг иргэдэд олгож, айл өрхөд галын аюулгүй байдал, пийшин зуухны бүрэн бүтэн ажиллагааны санамж, сайжруулсан шахмал түлшний зөв хэрэглээний талаар сургалт мэдээллийг хүргэсэн.</p> <p>Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг 1000 гаруй иргэн, аж ахуй нэгж байгууллагад 1812 ширхэг гарын авлага, сэрэмжлүүлэг зөвлөмжийг тараан өгч ажилласан.</p> <p>“Таван толгой түлш” ХХК-ийн Чингэлтэй дүүргийн Хэрэглэгчид үйлчлэх албанаас дататай угаарын хийн мэдрэгчийн аюулгүйн ажиллагаа болон уламжлалт пийшинд сууриллуулагч бортогоны талаарх зааварчилгааг өгсөн.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<p><b>Үүрэг, даалгавар ГУРАВ:</b> Түүхий нүүрс нэвтрүүлэхгүй, хэрэглүүлэхгүй байх чиглэлээр хяналтыг сайжруулах, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн технологийн чанар стандартад тогтмол хяналт тавьж ажиллах. /Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, бусад байгууллагууд/</p>				
3.	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/72, А/174 дүгээр хамтарсан тушаал, захирамжаар баталсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам, нийслэлийн Онцгой комиссын 2022 оны 03 дугаар хурлын тэмдэглэл, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1357 дугаар захирамж, дүүргийн Онцгой комиссын даргын 2022 оны 04 дүгээр албан даалгавар, Засаг даргын 2022 оны “Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, түүхий нүүрсний хяналтыг эрчимжүүлэх тухай” А/258 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газрын албан хаагчдын бүрэлдэхүүн 78 сайжруулсан шахмал түлшний дундын бөөний төв болон цэгүүдийн худалдан борлуулалт, нөөцийн</p>		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<p>хүртээмж, угаарын хийн дуудлага мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.</p> <p>Дүүргийн Онцгой комиссын даргын 2022 оны 04 дүгээр албан даалгавар, Засаг даргын 2022 оны “Сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, түүхий нүүрсний хяналтыг эрчимжүүлэх тухай” А/258 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Онцгой байдлын хэлтсээс Гүнтийн давааны байнгын ажиллагаатай цэгт нийслэлийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газрын тус бүр 3 алба хаагч 24 цагаар тогтмол хяналт тавин, үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Цэргийн штабын дарга Г.Ялалт, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга О.Мөнхжаргал, “Таван толгой түлш” ХХК-ийн борлуулалтын менежер Б.Төгөлдөр нар 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр сайжруулсан шахмал түлшний цэгийн үйл ажиллагаатай танилцаж, түлшний нөөц болон түгээлтэд хяналт тавьж ажиллалаа.</p> <p>Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62, 2022 оны 223 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн 7-21, 24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт сайжруулсан шахмал түлш борлуулж буй цэгүүдийн нөөцийн бүрдүүлэлт, борлуулалтад хяналт тавьж ажиллах нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын бүрэлдэхүүн тогтсон хуваарийн дагуу өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.</p>			
<p><b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Дүүргийн Засаг дарга нар төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар/</p>				
4.	<p><b>Нийслэлийн төсөв:</b> 2022 оны 11 сарын 23-ны өдрийн байдлаар нийслэлийн төсөвт 12,495.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 14,176.6 сая төгрөг төвлөрүүлж, 113.4%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p><b>Дүүргийн төсөвт:</b> 2022 оны 11 сарын 23-ны өдрийн байдлаар нийслэлийн төсөвт 136,709.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 125,705,8 сая төгрөг төвлөрүүлж, 91.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн төсөвт орох татварын төлөвлөгөөг 11 дүгээр сард өссөн дүнгээр биелүүлэх зорилт дэвшүүлэн нийтлэг ажиллагааг хэрэгжүүлж байна.</p> <p>Дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт 86 953.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 67 665.2 мянган төгрөг төвлөрүүлж 77,8%-ийн биелэлттэй байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<p><b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлт, төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх зэрэгт хяналт тавьж ажиллах.</p>				
5.	<p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад 2022 онд нийт 4007 өргөдөл, гомдол ирснээс 94% буюу 3776 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1% буюу 45 өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 4% буюу 186 өргөдөл гомдол одоогоор судлагдаж байна.</p>			

	<p>Иргэдийн өргөдөл гомдолд хариу өгсөн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Утсаар 47.94% буюу 1832</li> <li>➢ Мессежээр 34.07-% буюу 1302</li> <li>➢ Албан бичгээр 17.27*% буюу 660</li> <li>➢ Иргэнтэй биечлэн уулзсан 0.72-% буюу 27 хариуг тус тус өгсөн.</li> </ul> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газарт Edoc.ub.gov.mn нэгдсэн системээр нийт 43.076 албан бичиг ирснээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Хариутай-4051</li> <li>➢ Хариугүй-3925</li> <li>➢ Хугацаандаа шийдвэрлэсэн-41.466</li> <li>➢ Хугацаа хоцроож шийдвэрлэсэн-628</li> <li>➢ Судлагдаж байгаа-854</li> <li>➢ Бусад зөрчилтэй 128 албан бичиг байна.</li> </ul> <p>Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Хүний нөөц – Нийгмийн баталгаа-2024” арга хэмжээг батлах тухай 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ЗДТГ-ын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг ахиулах, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж, харилцаа хандлагыг сайжруулахаар “Мэдээллийн цаг”-аар дамжуулан, “Эртэч Монгол” хөтөлбөртэй хамтран “Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, Ажлын байрны аз жаргал” сэдэвт сургалтыг зохион байгуулж ЗДТГ-н нийт төрийн албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 3/2944 тоот албан бичгээр ЗДТГ-ын хэлтэс, албадын дарга нарт албан хаагчдын 2022 оны 11 дүгээр сарын цаг ашиглалтыг сайжруулан, албан хаагчдын хоцролт 100 минутаас хэтэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн дотор тайлан мэдээг ирүүлж ажиллахыг мэдэгдсэн.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<p><b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах ажлын хүрээнд зөвшөөрөлгүй гарааш, хайс, хашааг буулгаж орц, гарцыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах. /Захирагчийн ажлын алба, Газар зохион байгуулалтын алба, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
6.	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гараашны газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөний дагуу 10 байршлын 134 объектыг чөлөөлж, 87,100,000 төгрөгийн төсөвтэй газар чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Чөлөөлсөн байршлуудад иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл, боломжийг хангасан, ажлууд шат дараатай хийгдэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 1 дүгээр хороо 39 дүгээр цэцэрлэгийн хойд талд автомашины зогсоол</li> </ul>	=	Газрын зөрчил арилгах арга хэмжээний хүрээнд чөлөөлсөн газруудын тохижилтын ажил хийгдэнэ.	90

	<ul style="list-style-type: none"> <li>➤ 1 дүгээр хороо 39 дүгээр цэцэрлэгийн урд талд явган хүний зам, автомашины зогсоол</li> <li>➤ 4 дүгээр хороо орон сууцны 41 дүгээр байрны урд талд 11 гараашийг чөлөөлж явган хүний зам, автомашины зогсоол</li> <li>➤ 2 байршлын нийт 34 гарааш шүүхийн маргаантай тул чөлөөлөлтийн ажил түр зогссон</li> <li>➤ 4 дүгээр хороо Дипломат 95 дугаар байрны баруун талд-30 гарааш</li> <li>➤ 4 дүгээр хороо Орон сууцны 54 дүгээр байрны хойд талд-4 гарааш тус тус чөлөөлөгдсөн.</li> </ul> <p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, талаар авах зарим арга хэмжээний тухай “ А/585 дугаар захирамжийн хүрээнд нийт 105 байршлын 4088 м2 газрыг чөлөөлөхөөс 98 байршлын 3721 м2 газрыг чөлөөлсөн. Үлдсэн 7 байршил нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 24/17 дугаар тогтоолын хавсралт буюу нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах журмыг хангасан байгаа тул чөлөөлөх боломжгүй байна.</p>			
<p><b>Үүрэг, даалгавар ДОЛОО:</b> Иргэдэд ая тухтай орчин бүрдүүлэх чиглэлээр дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт хийгдэх ногоон байгууламж, явган болон дугуйн зам барих төлөвлөлтөө эрчимжүүлж, Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвөөс гаргасан судалгаатай нэгтгэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа боловсруулж нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах. /Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төв, Дүүргийн Засаг дарга нар, бусад хэрэгжүүлэг агентлаг харьяа газрууд/</p>				
7.	<p>Улсын төсвийн хөрөнгөөр 12 байршилд бетонон зам, байгалийн чулуун зам, хашаа шинэчлэх, зогсоол хийх зэрэг ажлууд төлөвлөгдөн ажлын даалгавар гаргуулж тендер зарлан “Трайзинг” ХХК шалгарч дүүргийн 12 дугаар хороонд бичил цэцэрлэг, 16 дугаар хороонд 2110м2 дугуйн зам, 19 дүгээр хороонд 405м2 эко хавтан, 172м2 явган зам тус тус хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дүүргийн хэмжээнд 2022 онд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн болон урсгал зардлын хөрөнгөөр нийт 8500м2 явган болон дугуйн зам хийгдэхээр төлөвлөгдсөнөөс өнөөдрийн байдлаар 5, 7, 8, 10, 15, 19 дугаар хороодод 2780 м2 нийт явган болон дугуйн зам хийгдээд байна. 2023 оны 2 дугаар улиралд 32-ын тойргоос 7 буудал, 17 дугаар сургуулийн уулзвараас Хайлаастайн эцэс хүртэл дугуйн зам хийхээр төлөвлөн судалгааны ажил хийгдэж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<p><b>Үүрэг, даалгавар НАЙМ:</b> Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, цаашид урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоод орчиндоо амны хаалт зүүлгэх зөвлөмж чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Дүүргийн Засаг дарга нар/</p>				
	<p>Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг ханган ажиллах тухай” Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын А/33 дугаар тушаал батлуулан, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.</p> <p>НЭМГ-ын шуурхай зөвлөгөөнөөр “Томуу томуу төст өвчний идэвхжил дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” албан даалгаврын биелэлтийг хангах</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	<p>Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн төвийн хүлээлгийн хэсэгт бөөгнөрөл үүсгэхгүй байх, хүлээгдэл чирэгдлийг бууруулах зорилгоор Эрүүл мэндийн төвийн хүүхдийн кабинетыг чөлөөлөн, амралтын өдрүүдэд 11:00-21:00 цагийн хооронд амбулаторийн хүүхдийн эмч, дархлаажуулалтын эмч, өсвөр үеийн эмч, хүүхдийн ерөнхий мэргэжилтэн нарыг хуваарийн дагуу хоёр ээлжээр ажиллуулж байна.</p> <p>Хүүхдийн хүлээн авах яаралтай тусламжийн шуурхай байдлыг хангах үүднээс хүүхдийн хүлээн авах яаралтай тусламжийн хэсгийг хоёр болгон зохион байгуулж шаардлагатай үед эмч, сувилагчийг нэмэлтээр дуудан ажиллуулж байна.</p> <p>Цаашид өвчлөл ихсэж орны ачаалал нэмэгдсэн үед төлөвлөгөөний дагуу дотрын 1-р тасгийн орыг хүүхдийн тасагт шилжүүлэн ажиллахаар бэлтгэл байдлыг хангасан.</p> <p>Хүүхдийн орны эргэлт 5,2%-тай, тасагт ирж хэвтсэн хүүхдүүдийн дийлэнх нь залгиур төвөнхийн үрэвсэл, бөглөрөл ихтэй, ханиалгах, халуурах гэсэн зовуурьтай, уушгины хатгалгаатай, хавсарсан гүйлгэлтийн шинж тэмдэгтэй хүүхдүүд байна. Эмчилгээнд үүсгэгчийн эсрэг, шинж тэмдгийн эмчилгээ болон амьсгалын замын халдварын хүндрэл давамгайлсан тохиолдлуудад сэргээн засах эмчилгээг хавсран хийж байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв нь Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед зөвлөгөө, мэдээлэл өгөх утсыг /7011-0279/ 24 цагаар тогтмол ажиллуулан үйлчлүүлэгчдэд зөвлөгөө, мэдээллийг хүргэж байна.</p> <p>Хүүхдийн тасагт хэвтэж буй хүүхдүүдэд болон асран хамгаалагчдад халдвараас сэргийлэх үүднээс маск зүүлгэх, гараа угаах шаардлагыг тогтмол тавьж ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн хүлээн авахын үзлэгийн ачааллыг бууруулах, яаралтай тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эрэмбэлэн ангилалтын сувилагчийг томилон ажиллуулж, үйл ажиллагааг жигдрүүлсэн.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн халдварт өвчин хариуцсан эмч нартай хуралдан, гэрийн эргэлтийг сайжруулах, эрэмбэлэн ангилалт хийх, орчилд орж байгаа вирусийн онцлог, авах арга хэмжээний талаар зөвлөгөөг иргэдэд хүргэн ажиллах чиглэлийг өгсөн.</p> <p>Цэцэрлэг, сургуулийн эмч нарт анги танхимд сурагч хүүхдүүдийг маск зүүлгэх, гар угаах, агаарыг тогтмол сэлгэж байх чиглэлийг өгөн ажиллаж байна.</p>			
<p><b>Үүрэг, даалгавар ЕС:</b> Дүүргийн Засаг дарга нар өөрсдийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нөхцөл байдалтай газар дээр танилцаж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Дүүргийн Засаг дарга/</p>				
	<p>Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Засаг дарга 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, дүүргийн иргэдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, тулгамдсан асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар Эрүүл мэндийн төвийн дарга Э.Наранхүү, Эмчилгээ эрхэлсэн</p>	<p>=</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	<p>90</p>

<p>Орлогч дарга Х.Чинзориг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан орлогч дарга Н.Нямсүрэн нар танилцуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв нь өнөөдрийн байдлаар 381 ажилтан, албан хаагч ажиллаж, 1-21, 24 дүгээр хорооны Өрхийн Эрүүл Мэндийн төвүүдэд 252 эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан ажиллаж байна.</li> <li>➤ Зарим нарийн мэргэжил шаардсан эмч, эмнэлгийн ажилтан дутагдалтай байна. 2022 оны 8 дугаар сараас нийт ажилтнуудын үндсэн цалинг 30%-р нэмэгдүүлсэн нь ажиллах хүч нь тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлж байна.</li> </ul> <p>Орон нутгийн төсвөөс дэмжиж шийдвэрлэж болох эсэх, дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлэх асуудлуудаар санал солилцон, иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах үйлсэд хамтран ажиллаж, тодорхой шийдвэр гаргаж ажиллахаар боллоо.</p> <p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар нь дүүргийн Эрүүл мэндийн нэгдсэн төв барих 2.8 га газрыг бүрэн чөлөөлөхөд 6,8 тэрбум төгрөгийг дүүргийн төсвөөс зарцуулсан.</p> <p>ЭМТ-н Хүүхдийн тасаг, хүүхдийн эрчимт эмчилгээний хэсэгт томуу, томуу төст өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад дэмжлэг үзүүлж 2022 оны 11 дүгээр сард дүүргийн төсвөөс нийт 67.0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль”-н дагуу дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд холбогдох бичиг баримтыг хүргүүлсэн.</p>			
---	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА  
ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.БАЯРМАА

Н. НАРАНЗУЛ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ